



ЭРЭЭНЦАВ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

2025 оны 04 дүгээр
сарын 25-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Эрээнцав ХК-ийн нийт Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал /ХЭХ/ 2025.04.25-ны өдрийн 16:00 цагт Улаанбаатар хот, БЗД-ийн 6-р хороо, 75/1-10 тоот байранд хуралдав.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ц.Лхагвадорж хурлыг нээж, хуралд компанийн нийт хувьцааны **76.02%** буюу 75,831ш хувьцааны эзэмшигчид оролцож байгааг мэдэгдэж, ирцийг танилцуулав. Үүнд:

1. Сийс гэйт ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Л.Ням: 30,000 ш хувьцаа, 30.08% ;
2. Агро кор Эл ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Д.Эрдэнэзаяа: 30,000 ш хувьцаа, 30.08% ;
3. Иргэн З.Мөнхбат: 12,122 ш хувьцаа, 12.16% ; нар оролцов.

Компанийн тухай хуулийн 64-р зүйлийн 64.1-т заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2025.03.01-ний өдрөөр тасалбар болгож хувьцаа эзэмшигчдийг бүртгэсэн бөгөөд Сийс гэйт ХХК-ийн Гүйцэтгэх захирал Л.Ням, Агро кор-Эл ХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Эрдэнэзаяа, иргэн З.Мөнхбат нар хуралд оролцож байгааг танилцууллаа.

Түүнчлэн компанийн тухай хуулийн 94-р зүйлийн 94.2, Эрээнцав ХК-ийн дүрэм, Эрээнцав ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах журмын 6.7, Аудитын Бодлогын баримт бичгийн 1.2, 9.1, Компанийн засаглалын кодексийн тайлангийн 4.2-р заалтууд, ТУЗ-ийн 2025.04.25-ны өдрийн ТУЗ-06/2025, Аудитын хорооны АХ-02/2025 тоот тогтоолуудыг тус тус үндэслэн хөндлөнгийн аудитор Г.Зинамидэр ХЭХ-д оролцож байгааг мэдээллээ.

Компанийн тухай хуулийн 69-р зүйлийн 69.1-рт нийт саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно гэж заасны дагуу хурлын ирц бүрдсэн тул ТУЗ-н дарга Ц.Лхагвадорж хурлыг үргэлжлүүлж, дэгийн дагуу Хурлын дарга, Тооллогын комисын дарга, гишүүдийг сонгож, батлахыг хувьцаа эзэмшигчдээс хүслээ.

ТУЗ-ийн 2025.02.10-ны өдрийн ТУЗ-03/2025 тоот тогтоолд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар Ц.Лхагвадоржийг, Тооллогын комисын даргаар Л.Давааг, гишүүдэд Г.Одгэрэл, Л.Ням нарыг сонгохыг хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчид 100% дэмжиж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 1-р тогтоолыг гаргахаар тогтлоо.

ТУЗ-ийн 2025.02.10-ны өдрийн ТУЗ-03/2025 тоот тогтоолд заасны дагуу ХЭХ-аар хэлэлцүүлэх асуудлуудыг хурал даргалагч Ц.Лхагвадорж танилцууллаа. Үүнд:

1. Компанийн 2024 оны Үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Компанийн 2024 оны Санхүүгийн тайлангийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
3. ТУЗ-ийн гишүүдийг сонгох, зарим гишүүний бүрэн эрхийг дуусгавар болгох;
4. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
5. Бусад;

Хурлаар хэлэлцэх асуудлуудыг хувьцаа эзэмшигчид 100% дэмжиж баталлаа.

Хэлэлцсэн нь:

1. Компанийн тухай хуулийн 76-р зүйлийн 76.1.11-д ТУЗ нь компанийн жилийн үйл ажиллагааны тайлангийн талаар дүгнэлт гаргаж, ХЭХ-д танилцуулж, батлуулна гэж заасны дагуу ТУЗ-н 2025.04.25-ны өдрийн ТУЗ-04/2025 тоот тогтоолоор баталсан дүгнэлтийг танилцууллаа.

2. Компанийн тухай хуулийн 76-р зүйлийн 76.1.11-д ТУЗ нь компанийн жилийн санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, ХЭХ-д танилцуулж, батлуулна гэж заасны дагуу ТУЗ-н 2025.04.25-ны өдрийн ТУЗ-05/2025 тоот тогтоолоор баталсан дүгнэлтийг танилцууллаа.

3. ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшиж буй Лутсайханы Тунгалагтамирын талаар танилцуулж, Компанийн тухай хуулийн 79-р зүйлийн шаардлагыг хангаж байгааг мэдээллээ.

4. Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.13-т ХЭХ нь ТУЗ-н гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох бүрэн эрхтэй гэж заасны дагуу цалин урамшууллын хэмжээг хувьцаа эзэмшигчдийн санал хураалтаар шийдвэрлэх талаар танилцууллаа.

5. Хувьцаа эзэмшигчдийн зүгээс бусад асуудалд оруулах ямар нэгэн санал ирүүлээгүй байна.

Хэлэлцэх асуудлуудтай холбогдуулан хувьцаа эзэмшигчид зарим нэг зүйлийг тодруулж, хэлэлцээд ТУЗ-н 2025.04.25-ны өдрийн ТУЗ-05/2025 тоот тогтоолоор баталсан саналын хуудсаар саналаа өгч, нийт асуудлуудыг шийдвэрлэхээр тогтлоо.

Санал хураалт:

Хувьцаа эзэмшигч бүрт хэлэлцсэн бүх асуудлаар санал өгөх хуудсыг Тооллогын комиссоос тараан өгч санал авсан. Үүнд:

1. 2024 оны Үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтийг Зөвшөөрөх, Татгалзах, Түтгэлзэх;
2. 2024 оны Санхүүгийн тайлангийн дүгнэлтийг Зөвшөөрөх, Татгалзах, Түтгэлзэх;
3. ТУЗ-ийн гишүүнийг сонгохыг Зөвшөөрөх, Татгалзах, Түтгэлзэх;
4. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг сонгох;

Хувьцаа эзэмшигчид саналаа тэмдэглэж албажуулсны дараа Тооллогын комис саналын хуудсуудыг хүлээн авч, нийт саналыг кумулятив аргаар тооллоо. Санал хураалтын дүнг нэгтэж, Санал хураалтын дүнгийн тухай 2025.04.25-ны өдрийн ТК-01/2025 тоот тогтоолыг албажуулан ХЭХ-д танилцууллаа. Үүнд:

1. Компанийн 2024 оны Үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтийг батлах: **100% Зөвшөөрсөн;**
2. Компанийн 2024 оны Санхүүгийн тайлангийн дүгнэлтийг батлах: **100% Зөвшөөрсөн;**
3. ТУЗ-ийн гишүүнд Л.Тунгалагтамирыг сонгох: **100% Зөвшөөрсөн;**
4. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ 600.000 төг: **100% Зөвшөөрсөн;**

Шийдвэрлэсэн нь:

Санал хураалтын дүн болон Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас дараах шийдвэрийг гаргав. Үүнд:

1. ХЭХ-ын Тооллогын комиссын ТК-01/2025 тоот тогтоолыг хүлээн авах;
2. 2024 оны Үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтийг хүлээн авах;
3. 2024 оны Санхүүгийн тайлангийн дүгнэлтийг хүлээн авах;
4. ТУЗ-ийн гишүүнд Л.Тунгалагтамирыг сонгох;
5. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг 600.000 төгрөгөөр тогтоох;
6. ХЭХ-аар хэлэлцсэн асуудал бүрээр тогтоол гаргах;

зэрэг болно. Хувьцаа эзэмшигчдийн хурал 18:00 цагт дуусав.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА:

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:

